

**ЖОРЖ КЕННАН: ДЭЛХИЙН П ДАЙНЫ
ДАРАА АНУ-ЫН ГАДААД БОДЛОГЫГ
ҮНДЭСЛЭГЧДИЙН НЭГ**

**Ц.Батбаяр, дэд эрдэмтэн,
Монголын АНУ судлалын
төвийн дэд тэргүүн**

Олон улсын харилцаанд "хүйтэн дайны" эрин төгсөж, хоёр туйлтай тогтолцоо олон туйлтай руу шилжих шилжилтийн шатандаа явж байна. Тэгвэл өнөөгөөс 50 хүрэхгүй жилийн өмнө дэлхийн П дайн төгсгөлдөө дөхөж дайны дараах дэлхийн дэг журам ямар байх нь бүхний анхаарлыг татаж байлаа. Шинэ дэг журам дайнд ялан дийлж гарсан ЗХУ болон АНУ гэсэн хоёр их гүрний харилцаан дээр тогтож байв.

Дайны дараах АНУ-ын гадаад бодлогыг тэр үед төрийн нарийн бичгийн даргын албыг хашиж байсан Жорж Маршалл, ДинАчесон нарын нэртэй холбон үзэх нь нийтлэг байдаг. Харин тэр үед төрийн департаментийн бодлого боловсруулах зөвлөлийн захирлаар ажиллаж байсан Жорж Кеннаны нэр тэр болгон сонин тэргүүн нүүрт гарч байсангүй. Гэтэл "хүйтэн дайны" эхэн үед Америкийн гадаад бодлогын чиг шугам, концепцийг боловсруулахад түүний гүйцэтгэсэн үүрэг ролийг бууруулах аргагүй юм.

22 настай Жорж Кеннан анх 1926 онд дипломат албанд нэгджээ. Түүнийг Оросын чиглэлээр бэлтгэх зорилгоор Берлиний их сургуулийн орос судлалын ангид 1929-1931 онд 2 жил ном үзүүлжээ. Кеннан болон бусад срос хэлтэй залуу дипломаатуудыг тэр үед Таллин болон Ригад суулгахаар томилсон нь санамсаргүй биш байв. Эдгээр хотоос Зөвлөлт орны байдлыг ажихад туйлын тохиромжтой гэж үзэж байлаа. Рига дахь ЭСЯ-нд 1931-33 онд ажиллах хугацаандаа Кеннан Зөвлөлтөөс дүрээгсэдтэй байнга уулзаж, тэндхийн байдлыг соргогоор ажиглаж сурчээ.

Москвад томилогдсон америкийн анхны элчин сайд Буллитыг дагалдан анх ЗХУ-д очих боломж түүнд 1933 оны 12 дугаар сард олдov. Тэрбээр Москвад үргэлжлэн суух болж 1935 онд түр зуур Венад томилогдсныг эс тооцвол 1937 оны найман сар хүртэл Москвад суужээ. Энэ хугацаанд түүний Зөвлөлт нийгмийн үзэх үзэл төлөвшин тогтож, Зөвлөлт-Америкийн харилцааны ойрын болон хэтийн төлөвийг эргэцүүлэн бодох болжээ. Ялангуяа Зөвлөлт-Америкийн харилцааны хэтийн төлөвийн талаар Кеннан өөдрөг бус

үзэлтэй байв. Ирээдүйд ч гэсэн өнгөрсөнтэй адил түүх, газарзүйн хүчин зүйлүүд энэ харилцаанд давамгайлах болно гэж тэрбээр итгэж байлаа.

Чехославакийн хувь заяаг шийдсэн дуулиант Мюнхены гэрээ байгуулагдах тэр үед Жорж Кеннан Прага дахь АНУ-ын Консулын газарт томилогдон иржээ. Дэлхийн II дайны жилүүдэд тэрбээр зөвхөн Прага төдийгүй Европын олон өнцөгт очиж нацист Германы тоталитар дэглэмийн мөн чанарыг танин ойлгох, түүнийг Сталины дэглэмтэй харьцуулан үзэх оролдлого хийж байв. Дайны эцсээр Лондонд америкийн төлөөлөгч ийн зөвлөхөөр ажиллах хугацаандаа Кеннан дайны дараах Европын хувь заяаг ихэд анхаарч байлаа. Тэрбээр дайны дараа Европт шинээр холбооны улс байгуулах санааг дэвшүүлж байв. Энэ нь Германыг хэсэгчлэн хуваахгүй байх, түүнчлэн Европыг хүчтэй болгох зорилгод нийцнэ гэж тэрбээр итгэн энэ зорилгыг хэрэгжүүлэхэд АНУ чухал үүрэг рольтой хэмээн тооцож байлаа.

Жорж Кеннан 1946 оны 4 дүгээр сард Вашингтонд эргэн ирж эхлээд Үндэсний цэргийн коллежид, 1947 оны эхнээс Төрийн департаментийн Гадаад бодлого боловсруулах зөвлөлийн захирлаар ажиллах болжээ. Түүний төрийн бодлогыг боловсруулах чухал зангилааг гартаа авсан энэ үе нь дайны дараах дэлхий өртөнцийн шинэ харилцааг тогтоох үндсэн хүчин зүйл Америк-Зөвлөлтийн харилцааны нэрийн ээдрээтэй үетэй таарчээ.

Төрийн департаментанд ажиллахаар очихоос өмнө Кеннан Зөвлөлтийн асуудал, түүнд хэрхэн хандах АНУ-ын байр суурийг нарийн мэддэг болохоо харуулсан юм. Чикого, Сиэтл, Сан-Франциско зэрэг америкийн томоохон хотуудаар 1946 оны 7,8 дугаар сард явж америкийн олон нийтэд Зөвлөлтийн асуудлын мөн чанар, хоёр орны харилцааны цаашдын төлөвийг хэрхэн төсөөлж байгаагаа танилцуулах боломж Кеннанд олджээ. Тэрбээр цэргийн коллежид багшилж байх хугацаандаа усан цэргийн яамны сайд Форресталийн хүсэлтээр ЗХУ-ын гадаад бодлогын зорилго, практик, АНУ-ын бодлого ямар байх талаар мемурандум бичиж өгчээ. Америкийн гадаад бодлогын мэргэжилтний дунд нэр хүндтэй "Форик аффээрз" сэтгүүлийн 1947 оны 7 дугаар сарын дугаарт Кеннан уг материалыг нэрээ нууцлан "X" гэсэн нэрээр хэвлүүлсэн нь оны анхаарлыг татсан үйл явдал болов. Энэ өгүүлийг бичсэн хүн нь төрийн бодлогыг боловсруулах албанд томилогдсон Кеннан болох нь илэрснээр уг өгүүллээр дамжуулан засгийн газар өөрийн бодлогоо илэрхийлсэн гэсэн ойлголт төрсөн байна. Өгүүлийн үндсэн санаань "дайн дажингүй тогтвортой дэлхий өртөнцийн ашиг сонирхолыг оросууд эвдэхийг санаархсан тухай бүрт тэднийг шийдвэртэй сөрөн зогсох чадвартай" тийм л бодлого хэрэгтэй гэдэгт оршиж байлаа. Тиймээс ч Зөвлөлтийг "тогтоон барих" бодлогыг бодож боловсруулсан хүмүүсийн нэг хэмээн Кеннаныг судлаачид үздэг байна.

Дэлхийн II дайнд сүйдсэн Өрнөд Европыг эдийн засгийн хувьд сэргээн босгох Маршаллын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхэд Кеннан биечлэн оролцжээ. Хэрвээ Европт эдийн засаг, нийгмийн хямрал үргэлжлэн ужиграх аваас дэлхийн эдийн засгийн амьдралд том цохиат болохоос гадна энэ тогтворгүй байдлыг даалмдуулан коммунистууд Өрнөд Европт засгийн эрхэнд гарснаар Америкийн аюулгүй байдалд ноцтой аюул үүснэ гэж тэрбээр үзэж байв. Иймд Европын аль нэг оронд хэсэгчилсэн тусламж үзүүлэх бус, Өрнөд Европыг хөл дээр нь босгох иж бүрэн программ хэрэгтэй гэдэгт Кеннан итгэлтэй байжээ. Маршаллын төлөвлөгөө 1948-1949 онд хэрхэн хэрэгжиж буйг ажиглаж байсан Кеннан хожим нь "Энэ төлөвлөгөө тун амжилттай болж бидний найдаж байснаас богино хугацаанд үр дүнгээ харуулсан юм. 18-хан сарын дараа Өрнөд Европ сэргэн босох зам дээр бат зогсож чадсан нь бидний өөдрөг тооцооноос ч давж, Өрнөд Европ коммунистуудын гарт орох тэр аюул ард хоцорсон гэдэг нь тодорхой болсон юм" гэж бичжээ.

Кеннаны үйл ажиллагааны хүрээнд Европ төдийгүй Ази, тухайлбал Алс Дорнод ч хамрагдаж байлаа. Тэрбээр Японы талаарх АНУ-ын төрийн бодлогыг боловсруулахад биечлэн оролцож, дайнд сүйдсэн энэ орныг түргэн сэргээн босгож тогтворжуулахад ихээхэн анхаарчээ. Кеннан Японд 1948 оны 2 дугаар сард ирж генерал Макартуртай уулзан Японы бодит байдалтай биечлэн танилцсан байна. Сарын дараа Кеннан төрийн нарийн бичгийн дарга Маршаллд Японы талаарх саналаа өргөн барьжээ. Японы эдийн засгийг сэргээн босгоход шууд санхүүгийн тусламж үзүүлэх, Японыг сульдын доройтуулж болзошгүй дайны төлбөр төлүүлэх зэрэг бодлогыг цуцлах, Японы өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх замаар АНУ-ын холбоотон болгох саналыг дэвшүүлжээ. Кеннаны энэ саналыг бүгд нэгэн дуугаар зөвшөөрөн хүлээн аваагүй бөгөөд хэрхэн хэрэгжүүлэх талаар ч зөрчилтэй байжээ. Харин 1950 онд дэгдсэн Солонгосын дайн энэ бүх маргааныг эцэс болгож бүх асуудлууд Японы талд ашигтайгаар шийдвэрлэгдсэн билээ. Кеннан Японы эдийн засаг, улс төрийг сэргээн тогтворжуулахад оруулсан хувь нэмрээ засгийн газарт алба хаших хугацаандаа байгуулсан Маршаллын төлөвлөгөөний дараах томоохон үйл хэрэг гэж үздэгээ хожим нь дуртгалдаа бичжээ.

Кеннан 1950 оноос эхлэн төрийн албанаас хөндийрч 1952 онд Москвад элчин сайдаар богино хугацаанд, 1961-63 онд Югославт элчин сайдаар түр суусныг эс тооцвол АНУ-ын дипломат түүхийг бичих судалгаа шинжилгээний ажилд хүч хөдөлмөрөө зориулсан байна.